

Тшав.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА С.БААТАРЖАВ ТАНАА
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНООС
ЗӨВЛӨМЖ ХҮРГҮҮЛЭХ НЬ

2018 оны 05 дугаар сарын 31

№06

Улаанбаатар хот

Цагдаагийн алба хаагчдын 2018 оны хэрэгцээнд улсын төсвийн хөрөнгөөр худалдан авах дүрэмт хувцас, үндсэн болон туслах материалд үнийн санал ирүүлсэн оролцогчдын материалыг хянан үзээд:

Нэг: Үнэлгээний хорооны дүгнэлтээр Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 155 дугаар тогтоолоор батлагдсан загвар, барааны техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагад нийцсэн санал ирүүлсэн дараах оролцогчтой шууд гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, 10¹ дүгээр зүйл, Засгийн газрын 2015 оны 336, 2017 оны 286 дугаар тогтоол, Сангийн сайдын 2013 оны 125, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/280 дугаар тушаалыг тус тус үндэслэн хүргүүлж байна. Үүнд:

1. "Зорбиом" ХХК-тай цагдаагийн алба хаагчийн гэрэл ойлгогчтой зуны хантааз 7000 ширхгийг нийт 65,450,000.00 төгрөг /Жаран таван сая дөрвөн зуун тавин мянган/-өөр,
2. БНХАУ-ын "Beijing Xianghuashengshi Business Trade Center" Co.,LTD-тай цагдаагийн алба хаагчийн зангиа 3000 ширхгийг нийт 26,400 юань /Хорин зургаан мянга дөрвөн зуун/-иар,

Хоёр: БНХАУ-ын "Beijing Xianghuashengshi Business Trade Center" Co.,LTD-тай гэрээ шууд байгуулах үнийн санал нь уг барааг тус улсын Бээжин хотоос Монгол Улсын Улаанбаатар хот хүртэлх бүх зардал /тээвэр, даатгал, гааль/-ыг бэлтгэн нийлүүлэгч хариуцаж Олон Улсын Худалдааны /CIP/ нөхцлөөр нийлүүлэхээр ирүүлсэн үнэ болно.

Гурав: БНХАУ-ын Эрээн хотоос импортоор оруулан дээрх барааг Монгол Улсын Улаанбаатар хот дахь гаалийн баталгаат агуулахаас худалдан авагчийн агуулахад татаж, хүлээн авах хүртэлх холбогдох гааль, нэмэгдсэн өртгийн албан татвар болон бусад хураамж, тээврийн зардлыг худалдан авагч хариуцна.

Дөрөв: БНХАУ-ын "Beijing Xianghuashengshi Business Trade Center" Co.,LTD - д гэрээний холбогдох төлбөрийг төлөхөд юаныг Монгол банкнаас зарласан тухайн өдрийн ханшаар хөрвүүлж бэлтгэн нийлүүлэгчийн төлбөр хийх дансаар шилжүүлнэ.

Цагдаагийн алба хаагчдад гэрэл ойлгогчтой зуны хантаазыг нийт 64,450,000.00 төгрөг /Жаран дөрвөн сая дөрвөн зуун тавин мянган/-өөр дотоодын 1 аж, ахуй нэгж байгууллагаар, зангиаг нийт 26,400 юань /Хорин зургаан мянга дөрвөн зуун/-иар гадаадын 1 аж, ахуй нэгж байгууллагаар тус тус бэлтгэхээр шийдвэрлэснийг захиалагч Цагдаагийн ерөнхий газарт зөвлөж байна.